

**Нислэгийн цаг уурын төвийн  
2025 оны үйл ажиллагааны тайлан**

2025.12.10

**Зорилго:** Нислэгт цаг агаарын бүх төрлийн урьдчилсан болон бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчлэх, нислэгийн цаг агаарын мэдээний технологийг мөрдөж, нислэгийн саатлын тоог бууруулах, цаг агаарын бодит ажиглалтын мэдээний болон уур амьсгалын ажиглалтын мэдээний чанарыг сайжруулах, төв, орон нутгийн нисэхийн мэдээлэл үйлчилгээний ажилд хяналт шалгалт хийж, гарсан үл тохирлыг засаж залруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандарт, дүрэм журмыг мөрдүүлэх гарч болох аюул, эрсдэлийг тооцоолон заавар, зааварчилга боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, шагнаж урамшуулах, сургалт зохион байгуулах, чадварлаг, боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх, удирдлагаас гаргасан бодлого шийдвэрийг бусад түвшинд хүргэх, санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчинд ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилт тавин ажилласан. Төвийн 2025 оны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 99,3 хувьтай байна.

**Нэг. УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ:**

2025 онд Чингис хаан олон улсын нисэх буудалд олон улсын 15035, орон нутгийн 4822 онцгой ба тусгай үүргийн 123, Буянт-Ухаа олон улсын нисэх буудалд олон улсын 132, орон нутгийн 4111, онцгой ба тусгай үүргийн 658 нислэгт Чингис хаан буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ (TAF) 2494, урт хугацааны TAF мэдээ 1463, районы урьдчилсан мэдээ 3, аэродромын урьдчилсан мэдээ 730, аэродромын сэрэмжлүүлэг мэдээ 10, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 2491, хандлагын урьдчилсан мэдээ 8, “Буянт-Ухаа” орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ (TAF) 2491, урт хугацааны TAF мэдээ 1462, районы урьдчилсан мэдээ 1574, аэродромын урьдчилсан мэдээ 730, аэродромын сэрэмжлүүлэг мэдээ 9, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 1593, чиглэлийн урьдчилсан мэдээ 7181, угталтын урьдчилсан мэдээ 2494, өндрийн салхины урьдчилсан мэдээ 3390, SIGMET мэдээ 85, Тосонцэнгэл нисэх буудал орчмын богино хугацааны TAF мэдээ 763, Ханбумбат нисэх буудлын TAF 1867, хөөрөлтийн мэдээ 1384, хандлагын урьдчилсан мэдээ 4, Тавантолгой нисэх буудлын TAF 45, бусад нислэгийн бүсэд урьдчилсан мэдээ 2176 удаа тус тус зохиож үйлчилсэн байна. Төв орон нутгийн 68375 бодит мэдээ, 28377 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Цаг агаарын тоон прогнозын боловсруулсан үр дүнг зураглан 3 хүртэл домэйн (9 км, 3 км, 1 км) сонгон авч үр дүнгүүдийг 1 цагийн алхмаар бодуулан зураглан гаргах ажиллагааг үйлдвэрлэлд нэвтрүүлэн, нисэх буудал бүрийн хувьд загварын үр дүнгээр метеограммыг зураг болон текст хэлбэрээр гарган, аймаг хотууд болон нисэх буудал тус бүр дээр үр дүнг 1–4 хүртэлх элементээр зураглан мэдээлэл дамжуулах системд нэмэлтээр оруулж төв болон орон нутгийн синоптик инженерүүд урьдчилсан мэдээ зохиолтод 2025 оны 11 сарын 7-ны өдрийг хүртэл ашигласан ба бодолтын хугацаа урт, хоногт 2 бодож байсан тул зогсоосон.

а) Буянт-Ухаа ОУНБ орчмын богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 96.15%, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 94.41% байна.

б) Чингис хаан ОУНБ орчмын богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 94.87%, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 92.70% байна.

**с) Ханбумбат НБ орчмын урьдчилсан мэдээний таарц:**

Ханбумбат НБ орчмын мэдээний таарц 9 цаг						Дундаж таарц
МҮХ	Чиглэл	Хурд	Абх	Үүл	Үзэгдэл	
2024- 12 сар	87.74	87.03	99.59	100.00	95.66	94.00
2025- 1 сар	86.98	88.35	98.02	100.00	98.28	94.32
2025- 2 сар	84.28	85.32	98.28	100.00	98.77	93.33
2025- 3 сар	81.77	79.06	95.86	100.00	97.31	90.80
2025- 4 сар	83.32	77.70	99.48	98.43	97.07	91.20
2025- 5 сар	79.82	77.32	99.39	97.20	95.50	89.85
2025- 6 сар	86.42	77.89	100.00	99.21	92.86	91.27
2025- 7 сар	83.00	81.83	99.80	98.16	88.97	90.35
2025- 8 сар	89.76	85.35	100.00	98.79	93.15	93.41
2025- 9 сар	85.26	87.80	99.69	99.08	93.87	93.14
2025- 10 сар	85.29	87.25	99.56	100.00	98.59	94.14
2025- 11 сар	81.62	86.08	96.62	100.00	95.13	91.89
2025 он	84.61	83.42	98.86	99.24	95.43	92.31
2024 он	85.27	83.43	97.55	99.77	94.76	92.16
зөрүү	-0.66	-0.01	1.31	-0.53	0.67	0.15

## d)Тосонцэнгэл НБ орчмын урьдчилсан мэдээний таарц:

Тосонцэнгэл НБ орчмын мэдээний таарц 9 цаг						Дундаж таарц
МҮХ	Чиглэл	Хурд	Абх	Үүл	Үзэгдэл	
2024- 12 сар	85.71	100.00	100.00	100.00	78.57	92.86
2025- 1 сар	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00
2025- 2 сар	100.00	77.78	100.00	100.00	88.89	93.33
2025- 3 сар	94.74	87.82	92.98	100.00	84.21	91.95
2025- 4 сар	100.00	97.50	100.00	100.00	95.00	98.50
2025- 5 сар	100.00	83.33	100.00	100.00	94.44	95.56
2025- 6 сар						
2025- 7 сар						
2025- 8 сар						
2025- 9 сар						
2025- 10 сар						
2025- 11 сар						
2025 оны хагас жил	96.74	91.07	98.83	100.00	90.19	95.37

## Цаг агаарын байдлаас шалтгаалсан нислэгийн саатлын судалгаа:

Буянт-Ухаа ОУНБ-д цаг агаараас шалтгаалсан нислэгийн 11 саатал гарсан. Үүнээс хүлээсэн цуцалсан нислэгийн саатал 11 гарснаас мэдээ таарсан 8, мэдээ таараагүй 3 саатал гарсан. Буянт-Ухаа районы цаг агаараас шалтгаалсан саатал 24 . Районы мэдээ таарсан. Замын агаараас шалтгаалсан 4 нислэгийн саатал гарсан. Мэдээ таарсан.

д/д	ZMUB үзэгдэл	саатал			Буцсан			хүлээх нислэг үйлдсэн			2-т гарсан			хүлээсэн			
		нийт	таарсан	таараагүй	таф	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй
1	2024 оны 12 сар	2	2	0											2	2	0
2	3 сар	1	0	1	1										1	0	1
3	5 сар	1	1	0											1	1	0
4	6 сар	2		2	2										2		2
5	7 сар	1	1												1	1	
6																	
7	9 сар	4	4												4	4	
<b>2025 он</b>		<b>11</b>	<b>8</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>11</b>	<b>8</b>	<b>3</b>

Үзэгдэл элементээр нь ангилбал: Цас, цасан шургатайгаас хүлээсэн цуцалсан 1, утаа, будантайгаас 2 нислэг, үүлтэйгээс 1, дуу цахилгаантай бороо 2 нислэг, бороотойгоос 5 нислэг тус тус саатсан. Нийт 11 нислэгийн саатлын 80%-иас дээш таарцтай буюу 8 нь мэдээ таарсан, мэдээ таараагүй 3.

д/д	ZМУВ үзэгдэл	саатал				Буцсан			хүлээх нислэг үйлдсэн			2-т гарсан			хүлээсэн		
		нийт	таарсан	таараагүй	таф	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй
1	утаа, будан	2	2	0											2	2	0
2	цас/ цасан шурга/ нойтон цас	1	0	1	1										1	0	1
3	үүл	1	1	0											1	1	
	дуу цахилгаантай бороо	2		2	2										2		2
	бороо	5	5												5	5	
<b>2025 он</b>		<b>11</b>	<b>8</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>11</b>	<b>8</b>	<b>3</b>

Чингис хаан ОУНБ-д цаг агаараас шалтгаалсан нислэгийн 45 саатал гарсан. Үүнээс буцсан 3, 2-р тойрогт гарсан саатал гарсан 11, хүлээх нислэг үйлдсэн 6, хүлээсэн нислэгийн саатал 25 гарснаас мэдээ таарсан 28, мэдээ таараагүй 15 саатал гарсан.

д/д	ZМСК үзэгдэл	саатал				Буцсан			хүлээх нислэг үйлдсэн			2-т гарсан			хүлээсэн		
		нийт	таарсан	таараагүй	таф	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй
1	2024 оны 12 сар	0															
2	1 сар	1	1												1	1	
3	2 сар	2	2									1	1		1	1	
4	3 сар	2		2	1										2		2
5	4 сар	4		4	4							1		1	3		3
6	5 сар	0															
7	6 сар	7	4	3	3							3	3		4	1	3
8	7 сар	6	6			1	1					2	2		3	3	
9	8 сар	8	4	4	4	1		1	3	2	1	2	2		2		2
10	9 сар	2	1	1	1							2	1	1			
11	10 сар	1		1	1	1	0	1									
12	11 сар	12	10	2	1				3	3	0				9	7	2
<b>2025 он</b>		<b>45</b>	<b>28</b>	<b>17</b>	<b>15</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>6</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>11</b>	<b>9</b>	<b>2</b>	<b>25</b>	<b>13</b>	<b>12</b>

Үзэгдэл элементээр нь ангилбал: Цас, цасан шуургатайгаас 18, ББХ салхитайгаас 2, ЗЗХ-ын салхитайгаас 1, хөндлөнгийн салхитайгаас 2, шилжлэг салхитайгаас 4, дуу цахилгаантай бороотойгоос 14, манантайгаас 4 нислэг тус тус саатсан. Нийт 45 нислэгийн саатлын 80%-иас дээш таарцтай буюу 28 нь мэдээ таарсан, 17 мэдээ таараагүй.

д/д	ЗМСК	саатал				Буцсан			хүлээх нислэг үйлдсэн			2-т гарсан			хүлээсэн		
		нийт	таарсан	таараагүй	таф	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй
1	ББХ салхи	1	1									1	1				
2	цас/ цасан шуурга/ нойтон цас	6	2	4	3										6	2	4
3	хөндлөнгийн салхи	2	0	2	2							1		1	1		1
	шилжлэг салхи	4	4	0								4	4				
	дуу цахилгаантай бороо	14	10	4	4	1		1	2	2		4	4		7	4	3
	манан	4		4	4	1		1	1		1				2		2
	ЗЗХ салхи	1		1	1							1	0	1			
<b>2025 он</b>		45	28	17	15	3	1	2	6	5	1	11	9	2	25	13	12

Ханбумбат нисэх буудалд цаг агаараас шалтгаалсан 12 нислэгийн саатал гарсанаас буцсан 5, хүлээсэн 7 саатал гарсан. Урьдчилсан мэдээ таарсан 4, мэдээ таараагүй 8 саатал.

д/д	ЗМКВ	саатал				Буцсан			хүлээх нислэг үйлдсэн			2-т гарсан			хүлээсэн		
		нийт	таарсан	таараагүй	таф	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй
1	2024 оны 12 сар	1		1	1	1	0	1									
2	1 сар	2	2	0		2	2	0									
3	2 сар	0															
4	3 сар	4	0	4	4	1		1							3	0	3
5	4 сар	1	1	0											1	1	0
6	6 сар	1	0	1	1	1	0	1									
7	9 сар	1	1	0		1	1	0									
8	11 сар	3	0	3	2										3	0	3
<b>2025</b>		13	4	9	7	5	3	2	0	0	0	0	0	0	7	1	6

Үзэгдэл элементээр нь ангилбал баруун хойдын салхитайгаас 4 нислэг, цас цасан шуурга, нойтон цас орсноос 6, хөндлөнгийн салхитайгаас 2 нислэг тус тус саатсан.

д/д	ЗМКВ	саатал				Буцсан			хүлээх нислэг үйлдсэн			2-т гарсан			хүлээсэн		
		нийт	таарсан	таараагүй	таф	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй	нийт	таарсан	таараагүй

1	БХ салхи	4	1	3	3										4	1	3
2	цас/ цасан шуурга/ нойтон цас	6	2	4	2	3	2	1							3	0	3
3	ББӨ салхи	3	1	2	2	3	1	2									
2025 он		13	4	9	7	5	3	2	0	0	0	0	0	0	7	1	6

### Хоёр. МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ:

Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Японы прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг 280 /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг, WAFS-ийн бүтээгдэхүүнүүдийг (aviationweather.gov сайтнаас) тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. Нөхцөл бүрдсэн үед суултын урьдчилсан мэдээ Чингис хаан ОУНБ-д 2, Ханбумбат нисэх буудалд 3 удаа, SIGMET мэдээ 35 зохиож, “Аюулгүйн бүс”-ээс дамжуулсан 64 AIRMET мэдээ, агаарын хөлгийн ажиглалтын мэдээ 4 хүлээн авч мэдээ зохиолтод ашигласан. Хэрэглэгч байгууллагуудыг бүх төрлийн урьдчилсан болон бодит мэдээ, локаторын мэдээ, мэдээллээр хоногийн 24 цагийн турш үйлчилж байна.

Мөн төвийн цахим хуудсаар дамжуулан хэрэглэгчдэд цаг агаарын мэдээллийг хүргэж байна. 2 сарын 4, 4 сарын 10,11-ний өдрүүдэд цаг агаарын аюултай үзэгдлийн талаар сэрэмжлүүлэг гарган хэрэглэгчдэд цахим шуудангаар болон төвийн цахим хуудсаар түгээсэн.

### Гурав. ЦАГ УУРЫН МЭДЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын Нислэгийн бодит мэдээний ажиглалтыг 30 минут тутамд “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын Нислэгийн бодит мэдээний ажиглалтыг цаг тутамд хийж, Мэдээлэл үйлчилгээний хэлтэс болон бусад хэрэглэгч байгууллагуудыг цаг агаарын бодит ажиглалтын мэдээ, шаардлагатай нөхцөлд нэмэлт мэдээллээр үйлчилж нислэгийн саатал, зөрчилгүй ажилласан.

Сар бүрийн 15, 25-нд Чингис хаан олон улсын нисэх буудлын өртөөнд MAWS-301 болон AWS-330, Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын өртөөнд MILOS-520 болон AWS-310 цаг уурын автомат станцуудын тоололтуудаар харьцуулсан ажиглалтыг хийхэд тоололтууд зөвшөөрөгдөх хэмжээнд байсан.

Чингис хаан, Буянт-Ухаа Олон улсын нисэх буудлуудын цаг агаарын бодит ажиглалтын мэдээгээр эх мэдээний сан үүсгэн ажиллаж байна.

Нислэгт зориулсан цаг агаарын бодит ажиглалтын мэдээг нисэхийн цахилгаан холбооны сүлжээ / AFTN /болон интернэт орчны мэдээ дамжуулалтын систем /MDS/-ээр олон улсын бүсийн мэдээллийн төвүүд болон орон нутгийн нисэх буудлуудад дамжуулж байна.

Нисэхийн цаг уурын бодит ажиглалтын үйлчилгээний хэсгийн 2025 оны Мэдээлэл үйлчилгээний ажлын нийт тоо/хүснэгтээр/:



“Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын бодит ажиглалтын мэдээг өмнөх оны дүнтэй харьцуулахад 0.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын бодит ажиглалтын мэдээг өмнөх оны дүнтэй харьцуулахад 0.2 хувиар буусан үзүүлэлттэй байна.


Чингис хаан олон улсын нисэх буудлын цаг агаарын бодит ажиглалтын мэдээний чанар:

	Бодит ажиглалтын мэдээний дүн (%)			
	Ажиглалтын чанар	Мэдээ зохиолт	Мэдээ дамжуулалт	Дундаж дүн %
Чингис хаан 2024 он	100	100	100	100
Чингис хаан 2025 он	100	100	99.3	99.8
Зөрүү				-0.2



Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын цаг агаарын бодит ажиглалтын мэдээний чанар:

	Бодит ажиглалтын мэдээний дүн (%)			
	Ажиглалтын чанар	Мэдээ зохиолт	Мэдээ дамжуулалт	Дүн %
Буянт-Ухаа 2024 он	100	100	99.8	99.9
Буянт-Ухаа 2025 он	100	100	100	100
Зөрүү				0.1



#### Дөрөв. УУР АМЬСГАЛЫН МЭДЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ:

“Буянт-Ухаа” орчмын Уур амьсгалын ажиглалтын мэдээг АК-01 код, аюул, агаар мэдээг FM-10-02 АҮУУЛ код, 10 хоног, сарын дундаж мэдээг FM 71-X CLIMAT кодын дагуу зохиож Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем / HMDTS /-ээр Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнд дамжуулж байна.

Уур амьсгалын горимын ажиглалтын материалыг цахим тооцоолуурт оруулан боловсруулж, тайланг Улаанбаатар ус цаг уур орчны шинжилгээний төвд хүргэж, хариу зааварчилгааг авч ажилласан.

Уур амьсгалын ажиглалтын ажиглалтын мэдээний чанар:

Уур амьсгалын мэдээний дүн(%)							Дундаж
	Хөтөлбөрийн биелэлт	Тайлангийн ирц	Ажиглалтын чанар	Мэдээ зохиолт	Шивэлт, материал боловсруулалт	Мэдээ дамжуулалт	Дүн%
2024 он	100	100	87.5	96.0	93.5	93.3	95.3
2025 он	100	100	85	98.6	96.3	93.3	95.5
Зөрүү	-	-	-2.5	2.6	2.8	-	0.2



Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал орчмын уур амьсгалын горимын ажиглалтын мэдээг өмнөх оны дүнтэй харьцуулахад 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Допплерын радараар үүл, хур тунадасны ажиглалт хийж, цаг агаарын урьдчилсан мэдээ гаргах, нислэгийн аюулгүй байдлыг хангахад нийт 2034200 мэдээгээр үйлчилсэн.

### **Тав. ЦАГ УУРЫН МЭДЭЭНИЙ ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭ:**

Хэрэглэгчдийн хүсэлтийн дагуу цаг агаарын зөвлөгөөг утсаар болон цахим шуудан, нислэгийн өмнөх ярианд тогтмол өгч байна. Даваа гараг бүр 7 хоногийн ажлын дүнг шуурхайд мэдээлж, 7 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ, төлөв, цаг агаарын зураг, нислэгийн саатал гарсан үеийн таарцыг гарган ИНЕГ-ын болон ЦУОШГ-ын шуурхайд бэлтгэж, төвийн цахим хуудсанд Чингис хаан ОУНБ, Буянт-Ухаа ОУНБ, Ханбумбат, Тосонцэнгэл, Таван толгой нисэх буудлуудын цаг агаарын 7 хоногийн төлөв, шинэ мэдээ мэдээллийг оруулж, төвийн гаднах цаг агаарын мэдээллийн самбар /урсдаг/-т аэродромын урьдчилсан мэдээг гаргаж хэрэглэгчдэд үйлчилсэн.

НААХЗА-ны байцаагчийн зөвлөмжийн дагуу Токиогийн галт уулын үнсний зөвлөмжийн төвөөс нийт 127 SIGMET мэдээ хүлээн авч МИАТ ХК, Аэромонголиа ХХК, Хүннү эйр ХХК-ний ZMUBMGLX, ZMUBMMLX, ZMUBMNGX AFTN хаягуудад дамжуулсан ба синоптик инженерүүдийн өдөр тутмын хийсэн ажлын судалгаанд мэдээ хүлээн авсан, дамжуулсан бүртгэлийг тогтмол хөтөлж байна.

Шилжилтийн улирлуудын цаг агаарын онцлог, нислэгт аюултай цаг агаарын үзэгдлүүдийн талаар товч мэдээлэл, санамжийг Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа алба салбар, орон нутгийн нисэх буудлууд, Монгол улсад нислэг үйлддэг авиакомпаниуд, бусад хэрэглэгчдэд цахим шуудангаар хүргүүлсэн.

1 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн цаг агаарын хэлэлцүүлгийг Буянт-Ухаа болон Чингис хаан ОУНБ-ын ээлжийн урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженерүүд, хэлтсийн дарга, ерөнхий инженер, аюулгүй байдал, чанарын хяналтын хэсгийн менежер, мэргэжилтнүүдтэй цахимаар (Google meet) хийж байгаа бөгөөд цаг агаарын бодит болон прогноз зураг мэдээ, тоон загварын үр дүн, радар, хиймэл дагуулын мэдээ зэрэгт дүн шинжилгээ хийж тухайн өдрийн цаг агаарын процессыг үнэлэн нэгдсэн дүгнэлт гаргаж байна. Ингэснээр урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженерүүдийн прогнозлох ур чадвар нэмэгдэх, урьдчилан мэдээний чанар таарц өсөх, цаашлаад нислэгийн аюулгүй ажиллагааг хангагдах, агаарын тээвэрлэгчдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх сайн талтай.

### **Зургаа. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:**

Төв, орон нутгийн нислэгийн цаг агаарын мэдээний хангалтад хяналт тавьж ажиллаж байна.

2024 оны 12 сард Олон улсын 1049, орон нутгийн 565, онцгой болон тусгай үүргийн 36, 2025 оны 1-11 сард Олон улсын 14118, орон нутгийн 8368, онцгой болон тусгай үүргийн 743 үйлчилснээс цаг агаараас шалтгаалсан нийт 183 нислэгийн саатал нэгтгэн Чингис хаан олон улсын нисэх буудалд 46 нислэгийн саатал гарснаас 24 урьдчилсан мэдээний таарц 80%-иас дээш таарцтайгаар мэдээлсэн ба 22 урьдчилсан мэдээг 80%-иас доош таарцтайгаар мэдээлсэн байна. Буянт-Ухаа ОУНБ-д цаг агаараас шалтгаалсан нислэгийн 14 саатал гарснаас мэдээ таарсан 9, мэдээ таараагүй 5 саатал гарсан. Орон нутагт нисэх буудалд 40 саатал гарснаас мэдээ таарсан 26, таараагүй 14, районы болон замын цаг агаараас шалтгаалсан цаг агаараас шалтгаалсан 83 гарснаас мэдээ таарсан 83, таараагүй мэдээний дүгнэлт 28, зөвлөмж 16 гаргасан. Үүнээс таараагүй мэдээний задлан судалгаа болон онцгой үзэгдлийн катологи 3 хийсэн байна.

Буудал орчмын бодит болон урьдчилсан мэдээнд сар бүр, чиглэлийн урьдчилсан мэдээ, угталтын урьдчилсан мэдээнд тухай бүрд, 7 хоногийн нисэх буудал орчмын төлөвт даваа гариг бүр хариу зааварчилга өгсөн. Өдөр тутам хяналт хийж тухай бүр нь залруулах арга хэмжээ авч ажилласан.

Орон нутгийн УЦУОШТ-үүдтэй цаг уурын сүлжээ, аймгуудын нисэх буудлуудтай AFTN, AMHS интернэт сүлжээ болон электрон шуудан, мэдээлэл дамжуулах сүлжээ (MDS), утсаар харилцан заавар, зөвлөмжийг тухай бүр нь тогтмол солилцож ажилласан.

Цаг агаарын хэлэлцүүлэгт Чингис хаан ОУНБ болон Буянт-Ухаа ОУНБ дахь ажлын байруудаас цахимаар холбогдох албан хаагчид болон ээлжийн инженерүүдийн хамт өдөр бүр тогтмол цаг агаарын хэлэлцүүлэгт оролцож байна.

3 дугаар сарын 04-нд Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн Урьдчилан мэдээлэхийн ерөнхий инженерээс мэдээлэх хуудас ирсний дагуу өдөр тутмын хяналт шалгалт хийж 3 дугаар сарын 12-нд Баянхонгор аймгийн УЦУОШТ-д Арга хэмжээ авах тухай албан тоот хүргүүлсэн.

Төвийн хэлтэс нэгжүүдэд улирал тутамд төлөвлөгөөт үзлэг шалгалтуудыг хийсэн. Тайлан, дүгнэлтийг Даргын зөвлөлд танилцуулж, зөвлөмж хүргүүлсэн.

5 дугаар сарын 1,2-ны өдрүүдэд Орхон аймгийн УЦУОШТ-д төлөвлөгөөт үзлэг шалгалт хийж, тайлан дүгнэлт бичиж, даргын зөвлөлд танилцуулж, албан бичгийн хамт хүргүүлсэн.

Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн 2025 оны БД-145/25 дүгнэлтэд тусгасан шаардлагын дагуу ANNEX-III-д орсон 81 дүгээр нэмэлт өөрчлөлт болон байгууллагын үйлчилгээний онцлог нөхцөл байдалд тохируулан Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журамд нэмэлт өөрчлөлт оруулсныг хянаж, 5 дугаар сарын 27-нд Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн даргад хүргүүлсэн.

Тосонцэнгэл НБ-д төлөвлөгөөт үзлэг шалгалтыг 7 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд хийсэн.

7 дугаар сарын 29-нд ММЛ616 аяллын дугаартай Чонжу-Мөрөн нисэх буудлын анхны нислэг үйлдэгдсэн.

8 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд Завхан аймгийн Тосонцэнгэл нисэх буудалд төлөвлөгөөт үзлэг шалгалт хийсэн тухай тайлан, дүгнэлт бичиж, 8 дугаар сарын 11-ний өдөр Даргын зөвлөлд танилцуулсан.

8 дугаар сарын 11-ний өдөр Ховд аймгийн УЦУОШТ-ийн нислэгийн цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтын байдалд төлөвлөгөөт үзлэг шалгалт цахимаар хийх ажлын удирдамж гарган, батлуулж, МҮХ-ийн даргад цахимаар хүргүүлж, 8 дугаар сарын 12-нд цахимаар үзлэг шалгалтын нээлтийн хурал хийж, удирдамж, шалгах хуудасны дагуу 8 дугаар сарын 12-15-нд өдрүүдэд шалгалт хийгдсэн.

8 дугаар сарын 12-ны өдөр Дорнод аймгийн УЦУОШТ-ийн нислэгийн цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтын байдалд төлөвлөгөөт үзлэг шалгалт цахимаар хийх ажлын удирдамж гарган, батлуулж, МҮХ-ийн дарга Ж.Мөнхчимэгт цахимаар хүргүүлж, 8 дугаар сарын 13-нд цахимаар үзлэг шалгалтын нээлтийн хурал хийж, удирдамж, шалгах хуудасны дагуу 8 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд шалгалт хийгдсэн.

Аюулыг мэдээлэх цонхоор 3 мэдээлэл ирсний дагуу холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэж шуурхай арга хэмжээ авч, мэдээллийн дагуу авсан арга хэмжээ авсан талаар тайлан бичсэн.

Баянхонгор аймгийн УЦУОШТ-д арга хэмжээ авах тухай 01/112 дугаартай албан бичиг хүргүүлсэн.

9 дүгээр сарын 04-ний өдөр Дорнод, Ховд аймгийн УЦУОШТ-ийн Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн төлөвлөгөөт үзлэг шалгалтын тайланг бичиж, даргын зөвлөлд танилцуулж, цахимаар хаалтын хурал хийж, тайланг албан бичгийн хамт хүргүүлсэн.

9 дүгээр сарын 18-ны өдөр Төв аймгийн УЦУОШТ-д төлөвлөгөөт үзлэг шалгалт хийж, тайлан дүгнэлтийг бичиж, 10 дугаар сарын 9-ний өдөр Даргын зөвлөлд танилцуулж, албан бичгээр тайланг хүргүүлсэн.

9 дүгээр сарын 25-нд АИР-аар зарлагдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хяналтын температурыг 2020-2024 оны мэдээллээр шинэчлэн боловсруулсан тухай ирүүлснийг хянаж, хариу явуулсан.

9 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд Архангай аймгийн УЦУОШТ-д төлөвлөгөөт үзлэг шалгалтыг цахимаар нээлтийн хурал хийж, шалгалт хийсэн. Архангай аймгийн УЦУОШТ-ийн нислэгийн цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтын байдалд төлөвлөгөөт үзлэг шалгалтын тайлан дүгнэлтийг бичиж, 10 дугаар сарын 20-ны өдөр төлөвлөгөөт үзлэг шалгалтын хаалтын хурал хийж, даргын зөвлөлд танилцуулж, 01/145 дугаартай албан бичгийн хамт хүргүүлсэн.

Баян-Өлгий аймгийн УЦУОШТ-ийн нислэгийн цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтын байдалд төлөвлөгөөт үзлэг шалгалтыг цахимаар хийх ажлын удирдамжийг цахимаар 10 дугаар сарын 17-нд хүргүүлсэн. НЦУТ-ийн даргын удирдамжийн хүрээнд нээлтийн хурал цахимаар хийж шалгах хуудас явуулж, 10 дугаар сарын 29-ний өдөр хаалтын хурлыг цахимаар хийж, даргад танилцуулан 10 дугаар сарын 30-ны өдөр 01/158 дугаартай албан бичгийн хамт тайлан дүгнэлтийг хүргүүлсэн.

Завхан аймгийн УЦУОШТ-ийн нислэгийн цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтын байдалд төлөвлөгөөт үзлэг шалгалтыг цахимаар хийх ажлын удирдамжийг цахимаар 10 дугаар сарын 17-нд хүргүүлсэн. НЦУТ-ийн даргын удирдамжийн хүрээнд нээлтийн хурал цахимаар хийж шалгах хуудас явуулж, холбогдох материалуудыг 10 дугаар сарын 21-нээс 10 дугаар сарын 24-ний өдөр шалган, тайлан дүгнэлтийг бичиж, 10 дугаар сарын 31-ний өдөр хаалтын хурлыг цахимаар хийж, даргын зөвлөлд танилцуулан, 01/161 дугаартай албан бичгийн хамт тайлан дүгнэлтийг хүргүүлсэн.

**Гаднаас хийгдсэн аудит, шалгалт:**

2024 оны 12 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд TUV CYPRUS (TUV NORD) олон улсын баталгаажуулалтын байгууллагын Монгол улс дахь төлөөлөгч компаниар Чанарын менежментийн тогтолцоонд ISO9001:2015 стандартын баталгаажуулалтын аудит шалгалтад хамрагдсан.

ИНЕГ-ын Агаарын навигаци аэродромын стандартын газраас Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт ИНД-174-ийн дагуу төлөвлөгөөт үзлэг шалгалт 2 дугаар сарын 03-ны өдрөөс 2 дугаар сарын 13-ны өдрүүдэд аудит шалгалтад хамрагдсан.

2025 оны АБЧХХ-ээс хийх үзлэг шалгалтын төлөвлөгөөнд нисэхийн хяналтын байцаагчийн зөвлөснөөр эрсдэлийн боломжийн үнэлгээ хийх талаар төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж даргаар батлуулсан.

Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн зөвлөснөөр санал асуулга хичээл зааж байгаа багш нарын үнэлгээ шинэчилсэн.

ИНЕГ-ын АНАСГ-ын Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн БД-137/25 дугаартай аюулгүй байдлын хэрэгжилтийн дүгнэлтэд тусгагдсан шаардлагуудыг хэрэгжүүлсэн тайланг албан бичгийн хамт АНАСГ-т хүргүүлсэн.

ИНЕГ-ын АНАСГ-ын Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн БД-145/25 дугаартай аудитын дүгнэлтэд тусгагдсан шаардлагуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, албан бичгийн хамт АНАСГ-т хүргүүлсэн.

3 дугаар сарын 20-нд Гэрчилгээжүүлэлт болон Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны төлөвлөгөөг цахим НААХЗА-д <https://asos.mcaa.gov.mn/auth/member/login>-д тайлан, төлөвлөгөөг оруулсан.

5 дугаар сарын 14-нд ИНЕГ-ын АНАСГ-ын иргэний нисэхийн хяналтын байцаагчийн дүгнэлт БД-425/25 дугаартай дүгнэлтэд тусгагдсан шаардлагын дагуу хэрэгжилтийн тайланг бичиж, албан бичгийн хамт ИНЕГ-т хүргүүлсэн.

6 дугаар сарын 02-нд ИНЕГ-ын АНАСГ-т иргэний нисэхийн хяналтын байцаагчийн БД-145/25 дугаартай дүгнэлтэд тусгагдсан шаардлагын хэрэгжилтийн тайлан бичиж, албан бичгийн хамт хүргүүлсэн.

6 дугаар сарын 03-нд Цахим НААХЗА-д иргэний нисэхийн хяналтын байцаагчийн БД-145/25, БД-137/25 дугаартай дүгнэлтэд тусгагдсан шаардлагын биелэлтүүдийг шивж оруулсан.

6 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд мэргэжлийн эрхийн инженер, техникч шалгалтын тестийг вариант болон ангилж, мэргэшлийн эрхийн шалгалтын тестийг шинэ программаар авч эхэлсэн.

Бодит ажиглалтын мэдээний RMK бүлгийн талаар цахимаар санал асуулга авахаар асуулт бэлтгэж, цахимаар хэрэглэгчдээс санал асуулга авч хэвээр үлдээхээр болсон.

Байцаагчийн 2025 оны БД-145/25 дүгнэлтэд тусгасан шаардлагын дагуу ANNEX-3-д орсон 81 дүгээр нэмэлт өөрчлөлт болон байгууллагын үйлчилгээний онцлог нөхцөлд байдалд тохируулан Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журамд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Иргэний нисэхийн хяналтын байцаагчид цаг агаарын мэдээ таараагүйгээс 2-р тойрогт гарсан, буцсан тохиолдлыг НХҮА-тай тулгасан цаг агаарын саатал, орон нутгийн нислэгийн 1-6 сарын нислэгийн саатал, Аюулыг мэдээлэх хуудсаар ирүүлсэн мэдээллийн бүртгэл болон дагуу авсан арга хэмжээний талаарх тайланг, гаднын нөлөөллөөс шалтгаалсан сүлжээний гэмтэл дутагдлын тоо, төлөвлөгөөт үзлэг шалгалтын тайлан дүгнэлтүүд, урьдчилан сэргийлэх зөвлөмж, төлөвлөгөөнүүдийг viber-аар явуулсан.

10 дугаар сарын 02-нд Нью клеос ХХК-ны JU8060 аяллын дугаартай агаар хөлөг Буянт-Ухаа- Баянхонгор чиглэлийн нислэг 08:31 цагт хөөрч ZMBH 12:46 цагаар тооцож байгаад 12:38 цагт суултад орж байхдаа салхинд цохиулж унасан тул Иргэний нисэхийн хяналтын байцаагчид холбогдох материалуудыг бүрдүүлж, хамтран ажиллах гэрээ, урьдчилсан мэдээний таарцыг дүгнэж хүргүүлсэн.

10 дугаар сарын 02-нд Нью клеос ХХК-ны JU8060 аяллын дугаартай агаар хөлөг Буянт-Ухаа- Баянхонгор чиглэлийн нислэг 08:31 цагт хөөрч ZMBH 12:46 цагаар тооцож байгаад 12:38 цагт суултад орж байхдаа салхинд цохиулж унасан тул Иргэний нисэхийн хяналтын байцаагчид холбогдох материалуудыг бүрдүүлж, хамтран ажиллах гэрээ, урьдчилсан мэдээний таарцыг дүгнэж хүргүүлсэн.

**Орон нутгийн УЦУОШТ-үүдийн нисэхийн цаг уурын үйлчилгээний хяналт шалгалт, зөвлөмж, зааварчилгаа:**

Нисэх буудлуудын буудал орчмын бодит болон урьдчилсан мэдээ, чиглэлийн урьдчилсан мэдээ, хөөрөлтийн урьдчилсан мэдээнд хариу зааварчилгаа өгсөн. Өдөр бүр хяналтыг хийж тухай бүр нь залруулах, сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.

Орон нутгийн 17 нисэх буудал орчмын 7 хоногийн төлөвийг даваа гариг бүр хянаж, нэгтгэж, холбогдох албан хаагчдад цахимаар хүргүүлж байна.

Нисэх буудлуудын AUTO METAR мэдээг шалгахад Чингис хаан ОУНБ-ын AMHS-ээр хаягаар ZMAT, ZMUG, ZMUL, ZMBU, ZMDZ нисэх буудлууд ирэхгүй байгааг тухайн аймгийн МҮХ-ийн дарга нарт мэдэгдэж, хаягийг нэмүүлж байна. 2024 оны 05 сараас Мөрөн нисэх буудлын болон ИНҮТ-НХНАА-ны холбогдох албан хаагчдад мэдэгдсэн хуваарьт техник үйлчилгээгээр явахаар оруулах хариу өгсөн.

Нисэхийн мэдээлэл боловсруулах систем (AMHS)- ээр METAR, TAF-г Чингис хаан болон Буянт-Ухаа ОУНБ-ын ZMUBYMYX, ZMSKYMYX хаягаар дамжуулах зөвлөмжийг өгсөн.



Харьцуулсан ажиглалт	22	22	23	19	28	28	0	24	6	0	24	22	22	18	0	0	0	0	0	0	0	258
7 хоногийн урьдчилсан төлөв	52	53	52	52	52	52	52	52	52	52	52	52	52	52	0	0	0	0	0	0	0	725
Цаг агаарын зөвлөгөө	8	0	5	144	0	365	209	2	0	1	6	0	134	9	0	0	0	0	0	0	0	883

**Буудал орчмын урьдчилсан мэдээний дундаж таарц:**

Нисэх буудал	Салхины чиглэл	Салхины хурд	Алсын барааны харагдац	Үүл	Үзэгдэл	Дундаж /%I
Өлгий	94.4	91.1	100.0	99.2	96.4	96.2
Дэглий цагаан	97.5	92.1	98.4	99.6	95.2	96.5
Ховд	98.7	97.4	99.7	99.9	99.3	99.0
Отгонтэнгэр	98.9	96.8	99.6	99.9	96.3	98.3
Алтай	90.4	77.8	98.9	99.5	93.4	92.0
Мөрөн	93.7	88.6	99.4	100.0	96.6	95.7
Гурвансайхан	86.5	79.2	99.1	99.9	96.9	92.3
Баянхонгор	91.9	90.2	99.8	99.7	96.3	95.6
Арвайхээр	99.2	98.2	100.0	100.0	98.7	99.2
Булган	96.9	90.8	99.4	99.8	96.3	96.7
Мандалговь	84.5	86.2	99.7	98.2	96.1	92.9
Өндөрхаан	98.5	98.7	99.9	100.0	99.2	99.3
Чойбалсан	98.6	99.1	100.0	100.0	100.0	99.5
Баруун-Урт	99.4	88.9	100.0	98.3	97.7	96.9

**Буудал орчмын урьдчилсан мэдээний дундаж таарцыг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд:**

УЦУОШТ-үүд	Өлгий	Дэглий цагаан	Ховд	Отгонтэнгэр	Алтай	Мөрөн	Гурвансайхан	Баянхонгор	Арвайхээр	Булган	Мандалговь	Өндөрхаан	Чойбалсан	Баруун-Урт
2024 он	96.78	96.76	98.78	98.20	89.68	95.72	93.04	94.51	99.91	96.12	94.44	97.67	98.07	93.24
2025 он	96.24	96.55	98.98	98.31	91.99	95.65	92.33	95.56	99.22	96.65	92.93	99.26	99.54	96.87
зөрүү	-0.54	-0.21	0.20	0.11	2.31	-0.07	-0.71	1.05	-0.69	0.53	-1.50	1.58	1.47	3.63

Ховд, Отгонтэнгэр, Алтай, Баянхонгор, Булган, Өндөрхаан, Чойбалсан, Баруун-Урт нисэх буудлын буудал орчмын урьдчилсан мэдээний таарц 0.11-3.63 хувиар өссөн, бусад нисэх буудлуудын таарц 0.07-0.71 хувиар буурсан байна.

**Нислэгийн саатал:** нисэх буудалд цаг агаараас шалтгаалж нийт 20 нислэг саатсан байна.

Д/д	Нисэх буудал	Нийт	Саатал		Цуцалсан		Хүлээсэн		Нислэгийн осол	
			таарсан	таараагүй	таарсан	таараагүй	таарсан	таараагүй	таарсан	таараагүй
1	Мөрөн	5	5		4		1			
2	Дэглий цагаан	3	1	2	1			2		
3	Баянхонгор	2	2		1				1	
4	Отгонтэнгэр	2	2		1		1			
5	Мандалговь	2	2		2					
6	Өлгий	2	2		1		1			
7	Гурвансайхан	2		2		1		1		
8	Чойбалсан	1	1		1					
9	Алтай	1		1				1		
<b>НИЙТ</b>		<b>20</b>	<b>15</b>	<b>5</b>	<b>11</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>1</b>	

Нисэх буудалд саатсан нислэгийг цаг уурын элементээр ялгавал:

Д/д	Нисэх буудал	Нийт	Саатал		Салхи		Алсын барааны харагдац, үзэгдэл		Үүл, үзэгдэл	
			таарсан	таараагүй	таарсан	таараагүй	таарсан	таараагүй	таарсан	таараагүй
1	Мөрөн	5	5				2		3	
2	Дэглий цагаан	3	1	2		1	1	1		
3	Баянхонгор	2	2		1				1	
4	Отгонтэнгэр	2	2				1		1	
5	Мандалговь	2	2		1		1			
6	Өлгий	2	2		1		1			
7	Гурвансайхан	2		2		2				
8	Чойбалсан	1	1						1	
9	Алтай	1		1				1		
<b>НИЙТ</b>		<b>20</b>	<b>15</b>	<b>5</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>6</b>	

Өмнөх өдрийн цаг агаарын зөвлөмжөөр нийт 10 нислэг саатсанаас хүлээсэн 1, цуцалсан 9 нислэг байна.

Д/д	сар өдөр	Аялалын дугаар	Нислэгийн чиглэл	Саатал (цаг)			Цаг агаар муу буудлын нэр	Төрөл	цаг агаарын шалтгаан
1	2024.12.17	MGL031	ZMCK-ZMKD	6:50	18:11	11:21	ZMKD	хүлээсэн	5000 2000SE SN SCT027 BKN080
2	2024.12.17	MGL051	ZMCK-ZMUG	15:30			ZMUG	цуцалсан	2000 SN BR OVC020
3	2025.03.08	MGL067	ZMCK-ZMUL	7:25		хоног	ZMUL	цуцалсан	шороон шуургатай
4	2025.03.10	9991	ZMUB-ZMBH	8:00			ZMBH	цуцалсан	шороон шуургатай
5	2025.03.10	MGL061	ZMCK-ZMDN-ZMAT	9:00			ZMDN, ZMAT	цуцалсан	цасан шуургатай
6	2025.03.25	MGL7083	ZMCK-ZMKB	10:00			ZMDZ	цуцалсан	шороон шуургатай
7	2025.04.10	MGL061	ZMCK-ZMDN	11:00			ZMDN	цуцалсан	орон шуургатай
9	2025.09.01	MGL067	ZMCK-ZMUL	12:00		хоног	ZMUL	цуцалсан	салхитай
10	2025.11.14	MGL031	ZMCK-ZMKD	13:00	14:03	7:13	ZMKD	цуцалсан	салхитай цастай

Замын цаг агаараас шалтгаалж 18 нислэг саатсан байна.

Д/д	сар өдөр	Аялалын дугаар	Нислэгийн чиглэл	Саатал /цаг/			Цаг агаар муу буудлын нэр	Төрөл	цаг агаарын шалтгаан	Тайлбар
1	2025.01.30	MML3366	Цагаан суварга-ZMUB	11:00	0.634	0.176	Замын агаар	цуцалсан		
2	2025.07.10	MGW3011	ZMUB - Тусгал - ZMHG - ZMUB	6:30		хоног	Замын агаар	цуцалсан	бороотой	
3	2025.07.13	MGW3012	Тусгал-ZMUB	11:00		хоног	Замын агаар	цуцалсан	бороотой	
4	2025.07.13	MML3366	ZMUB-Тусгал-ZMUB	12:00		хоног	Замын агаар	цуцалсан	бороотой	
5	2025.07.14	MGW3012	Тусгал - ZMUB	10:00	14:00	4:00	Замын агаар	хүлээсэн	бороотой	
6	2025.07.14	VHZKA	ZMDZ -ZMDZ	9:00		хоног	бороотой	цуцалсан		
7	2025.07.14	VHCFL	ZMDZ -ZMDZ	9:00		хоног	бороотой	цуцалсан		
8	2025.07.15	VHZKA	ZMDZ -ZMDZ	9:00		хоног	Салхитай	цуцалсан		
9	2025.07.15	VHCFL	ZMDZ -ZMDZ	9:00		хоног	Салхитай	цуцалсан		
10	2025.07.21	MGW5111	Цагаан үүр сум-Тусгал	8:00	10:50	2:50	Замын агаар	хүлээсэн	бороотой	
11	2025.08.03	MGW5111	Ононгийн халуун рашаан-Хийморь хотхон-ZMUB	13:10	16:33	3:50	Замын агаар	хүлээсэн	үүлтэй	
12	2025.08.06	EAGLE 1	ZMUB-Ерөө сумын рн	7:00	10:18	3:18	Замын агаар	хүлээсэн	бороотой	
13	2025.08.17	EAGLE 1	ZMUB-Минжийн застав	12:00	15:01	3:01	Замын агаар	хүлээсэн	нам үүлтэй бороотой	
14	2025.08.20	AAA6777	Бүтээл ресорт-Хар усан тохой р	19:04	19:32	0:28	Замын агаар	хээрийн буулт хийсэн	нам үүлтэй бороотой	Хар усан тохойг 19:04-д тооцож байгаад 18:40-д цаг агаар муу шалтгаанаар Төв аймгийн Жаргалант-с баруун урд 20км зайд хээрийн буулт хийсэн. Эргэж 18:51-д хөөрч Хар усан тохой рн-г 19:32-д тооцож байна.
15	2025.09.05	9991	ZMMN-ZMHG	7:00	10:47	3:47	Замын агаар	хүлээсэн	будантай нам үүлтэй	
16	2025.10.13	9066	Хүдэр сум рн-ZMUB	8:00	11:50	3:50	Замын агаар	хүлээсэн	цастай	
17	2025.10.13	6999	ZMUB-Хялганат рн	7:00			Замын агаар	цуцалсан	цастай	
18	2025.10.13	9991	ZMBH-ZMAN рн-ZMBH	14:30			Замын агаар	цуцалсан	үүлтэй	

**Районы цаг агаараас шалтгаалж нислэг саатсан байна.**

Д/д	сар өдөр	Аялалын дугаар	Нислэгийн чиглэл	Саатал цаг/			цаг агаарын шалтгаан	Төрөл	Тайлбар
1	2024.12.04	EAGLE3	ZMUB-Мөнгөнморьт сум-Минжийн застав	8:00	13:54	5:54	Минж районд манантай үүлтэй	буцсан	Бэлтгэл ажил хангагдаагүй шалтгаанаар саатаж байгаад 09:48-д хөөрөөд 10:18-д буув. 11:06-д хөөрч Минж заставыг 11:40-р тооцож байгаад Минж район манантай битүү үүлтэй шалтгаанаар эргээд Мөнгөнморьт-д 11:36-д буув. 13:07-д хөөрч Минж заставд 13:54-д буув. 14:50-д хөөрч Мөнгөнморьт-д 15:26-д буув. 16:01-д хөөрч ZMUB 16:41-д
2	2025.03.13	9991	ZMUB-Шинэжинс	8:30		хоног	цастай	хүлээсэн	
3	2025.03.29	AAA6333	Түшиг сум рн-Түшиг сум рн	12:40		хоног	салхитай	цуцалсан	
4	2025.06.01	AA501	Их тэнгэр цогцолбор-Минжийн застав	7:10		хоног	нам үүлтэй бороотой	цуцалсан	
5	2025.06.08	1918	Хотонт-Хотонт	5:00		хоног	салхитай үүлтэй	цуцалсан	
6	2025.06.11	1918	Цэнхэр сум-Цэнхэр сум	5:00		хоног	бороотой	цуцалсан	
7	2025.06.12	1918	Цэнхэр сум-Цэнхэр сум	5:00		хоног	бороотой	цуцалсан	
8	2025.06.13	1918	Цэнхэр сум-Цэнхэр сум	5:00		хоног	бороотой	цуцалсан	
9	2025.06.14	1918	Цэнхэр сум-Цэнхэр сум	5:00	7:10	2:10	бороотой	хүлээсэн	
10	2025.06.23	AN-2	Сэлэнгэ аймаг- Баруун бүрэн сум	5:00	16:04	11:04	бороотой	хүлээсэн	
11	2025.06.23	1918	Их тамир сум рн-Өндөр-Улаан сумын рн	12:30		хоног	салхитай	цуцалсан	
12	2025.06.26	EAGLE2	ZMUB-Түнхэл	14:00		хоног	үүлтэй бороотой	цуцалсан	
13	2025.06.28	EAGLE2	ZMUB-ZMBN-ZMHG-Тэнгис	6:00		хоног	үүлтэй бороотой	цуцалсан	Хатгалд бороотой
14	2025.07.08	VHCFL	ZMDZ -ZMDZ	9:00		хоног	бороотой	цуцалсан	TEMPO 0800/0809 VRB08G13MPS 7000 TSRA
15	2025.08.19	VHNFH	ZMDZ-ZMDZ	8:00		хоног	Салхитай	цуцалсан	
16	2025.08.19	VHCFL	ZMDZ-ZMDZ	8:00		хоног	Салхитай	цуцалсан	
17	2025.08.19	VHZKA	ZMDZ-ZMDZ	8:00		хоног	Салхитай	цуцалсан	
18	2025.09.02	VHCFL	ZMDZ-ZMDZ	8:00		хоног	Салхитай	цуцалсан	
19	2025.09.02	VHZKA	ZMDZ-ZMDZ	8:00		хоног	Салхитай	цуцалсан	
20	2025.09.03	VHCFL	ZMDZ-ZMDZ	8:00		хоног	Салхитай	цуцалсан	
21	2025.09.03	VHZKA	ZMDZ-ZMDZ	8:00		хоног	Салхитай	цуцалсан	
22	2025.09.10	9991	ZMBH-ZMBH рн	7:00		хоног	салхитай	цуцалсан	
23	2025.09.10	VHCFL	ZMDZ-ZMDZ	8:00		хоног	Салхитай	цуцалсан	
24	2025.09.10	VHZKA	ZMDZ-ZMDZ	8:00		хоног	Салхитай	цуцалсан	
29	2025.10.14	9993	ZMDZ- Гурван тэс рн	10:30			салхитай	цуцалсан	

**Мэдээлэл солилцох үйлчилгээ:** Орон нутгийн УЦҮОШТ-үүд болон нисэх буудлуудтай Нислэгийн цаг уурын мэдээг мэдээлэл дамжуулах систем(MDS), нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний мэдээ зохицуулах систем (AMHS)-ээр нислэгийн цаг агаарын бүх

төрлийн бодит болон урьдчилсан мэдээг түгээж, хүлээн авч, интернэт сүлжээ болон электрон шуудан, утсаар харилцан заавар, зөвлөмжийг тухай бүр нь тогтмол солилцож ажилласан.

Арвайхээр нисэх буудлын цаг уурын автомат станц 2024.06.14-ний (08:50) өдрөөс гэмтэлтэй нөөц болох Өвөрхангай аймгийн УЦУОШТ-ийн цаг уурын автомат станцын салхины мэдрүүр гэмтэлтэй тул тойм урьдчилсан мэдээгээр үйлчилж байна.

### Нисэхийн цаг уурын үйлчилгээний ажлын дүн

УЦУОШТ-үүд	Баян-Өлгий	Увс	Ховд	Завхан	Говь-Алтай	Хөвсгөл	Өмнөговь	Баянхонгор	Өвөрхангай	Булган	Дундговь	Хэнтий	Дорнод	Сүхбаатар	Архангай	Орхон	Дархан-Уул	Сэлэнгэ	Төв	Говьсүмбэр	Дорноговь	
Шуурхай үйлчилгээ	100.00	98.33	100.00	100.00	99.17	100.00	98.33	95.83	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00
Мэдээ зохиолтын чанар	91.25	94.50	97.75	91.50	88.25	88.25	87.50	74.00	95.75	96.00	92.00	94.50	95.36	98.64	84.63	99.25	99.00	91.75	94.75	97.75	96.67	96.67
Шуурхай зохицуулалт	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00
Буудал орчмын урьдчилсан мэдээний таарц	96.24	96.55	98.98	98.31	91.99	95.65	92.33	95.56	99.22	96.65	92.93	99.26	99.54	96.87	-	-	-	-	-	-	-	-
Ачааллын коэффициент	1.20	1.16	1.38	0.79	0.66	2.81	3.95	1.58	0.60	1.47	0.73	1.25	0.25	0.08	0.53	0.13	0.14	1.23	1.03	0.00	0.22	
Дүн	98.08	98.50	100.00	98.24	95.51	98.78	98.50	92.93	99.34	99.63	96.96	99.69	98.98	98.95	95.41	99.88	99.81	98.48	99.28	99.25	99.11	

### Нисэхийн цаг уурын үйлчилгээний ажлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд:

	Баян-Өлгий	Увс	Ховд	Завхан	Говь-Алтай	Хөвсгөл	Өмнөговь	Баянхонгор	Өвөрхангай	Булган	Дундговь	Хэнтий	Дорнод	Сүхбаатар	Архангай	Орхон	Дархан-Уул	Сэлэнгэ	Төв	Говьсүмбэр	Дорноговь
2024 оны жилийн дүн	97.51	96.99	99.30	97.59	94.99	97.58	97.18	95.28	99.12	98.57	96.76	98.03	97.62	97.03	96.91	99.72	97.88	98.80	99.52	99.80	99.22
2025 оны жилийн дүн	98.08	98.50	100.00	98.24	95.51	98.78	98.50	92.93	99.34	99.63	96.96	99.69	98.98	98.95	95.41	99.88	99.81	98.48	99.28	99.25	99.11
зөрүү	0.57	1.51	0.70	0.65	0.52	1.21	1.32	-2.35	0.22	1.07	0.20	1.66	1.36	1.92	-1.50	0.16	1.93	-0.31	-0.24	-0.55	-0.11

Баян-Өлгий, Дэглий цагаан, Ховд, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай, Булган, Дундговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Орхон, Дархан аймгийн УЦУОШТ-ийн нисэхийн цаг уурын үйлчилгээний ажлын дүн 0.16-1.92 хувиар өссөн, бусад аймгийн УЦУОШТ-ийн нисэхийн цаг уурын үйлчилгээний ажлын дүн 0,11-2,35 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нисэх буудал дээрх цаг уурын автомат станцын байршил буюу шугаман өнцгийн хэмжлийн үр дүнгийн хуудсыг цуглуулж, нэгтгэсэн.

Үйл ажиллагааны ерөнхий зааварт орсон орон нутгийн нислэгийн цаг уурын үйлчилгээний байгууллагуудын байрлал, тоног төхөөрөмжийн байршил, үйлчилгээний цар хүрээний хүснэгтүүдийг шинэчилсэн.

Нисэх буудлуудын AUTO METAR мэдээний архивыг нисэх буудал тус бүрээс цуглуулж, цахим сан үүсгэсэн. Өлгий, Увс, Ховд, Алтай, Мөрөн, Өндөрхаан, Мандалговь, Гурвансайхан, Ханбумбат нисэх буудлуудын мэдээ 2014 оны 07 сараас 2024 оныг дуустал, Өндөрхаан нисэх буудлын зөвхөн 2024 оны мэдээ, Баруун-Урт нисэх буудлын 2020 он, Отгонтэнгэр нисэх буудлын мэдээ 2017 оны мэдээнүүдээс бусад оны мэдээнүүд ирсэн байна.

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албанаас и-мэйл ирүүлсний дагуу НМҮА-тай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ” 2.1.13-д тусгагдсан AIP хэвлэн нийтлэгдсэн мэдээлэлд жилд нэг удаа дүн шинжилгээ хийж дүгнэлтийг НМҮА-нд хүргүүлнэ гэсэн заалтын дагуу Нислэгийн цаг уурын үйлчилгээтэй холбоотой мэдээлэлд МҮХ-ийн дарга Б.Болормаатай хамт дүн шинжилгээний хийж, дүгнэлтийг АБЧХХ-т хянагдаж ирснийг, түүхий өгөгдөл хүлээн авах WIZARD PORTAL программд оруулж, илгээсэн.

Төв болон орон нутгийн 23 нисэх буудлын ажиглалтын цэгээс 45км доторх байр зүйн зураг гаргуулах талаар албан бичгийн төсөл болон хавсралтыг бэлтгэж Нисэхийн мэдээлэл үйлчилгээний албанд албан бичиг хүргүүлсэн. 23 нисэх буудлын ажиглалтын цэгийн байршлыг google.mn/maps-аар тодорхойлж, нисэх буудал тус бүрээр үүлний доод суурийн өндрийн харьцуулан тодорхойлох тэмдэгтүүдийг нэгтгэж хавсаргаж хүргүүлсэн.

Мэдээлэл дамжуулах системд Нам өндрийн чиглэлийн урьдчилсан мэдээ бичиж дамжуулахад тойм урьдчилсан мэдээ татагддаггүй байсныг Тоон загварчлал, судалгааны ахлах мэргэжилтнээр Нам өндрийн чиглэлийн урьдчилсан мэдээ бичих программд өөрчлөлтийг хийлгүүлж татагддаг, мөн шалгадаг болгосон.

Өндөрхаан нисэх буудал шинээр ашиглалтад орохтой холбогдуулан алсын барааны харагдцыг тодорхойлох тэмдэгтүүдийг шинээр сонгож, баталгаажуулахад зөвлөмж өгч, баталгаажуулах бичиг баримтыг хянасан.


Хүннү эйр ХХК-ны Чингис хаан -Мөрөн чиглэлд нисэх нислэгийн өндөр 9200м гэж э-мэйл ирсэн тул чиглэлийн урьдчилсан мэдээг өндрийн цаг агаараар бичих, Олон улсын нислэгийн чиглэлийн урьдчилсан мэдээ бичих зөвлөмжийг Хөвсгөл аймгийн УЦУОШТ-д өгсөн.

# Хүний нөөцийн үзүүлэлт


Нийт 54 албан хаагч

Дээд /Магистр 15 (27,8%),  
Бакалавр 30 (55,6%)  
Докторантур 1 (1,8%)

Эрэгтэй 21 (38,9%),  
Эмэгтэй 33 (61,1%)



## ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦАА



Сургалт, үйлдвэрлэлийн дадлага:

БОУАӨЯ-аас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сургалтад 7 албан хаагч цахимаар оролцсон. (Удирдлагын академи)

Архивын ерөнхий газраас ирүүлсэн 2025 оны Сургалтын төлөвлөгөөтэй танилцаад, оролцох шаардлагатай хичээл сургалтын санал, мөн ЦУОШГ-ын Сургалтын төлөвлөгөөнд тус төвөөс оруулах сургалтыг Цаг уур, орчны шинжилгээний газрын Бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Уянгад цахимаар файл явуулсан. Иргэний агаарын тээврийн нислэгт цаг агаарын бодит ажиглалтын мэдээгээр үйлчилдэг инженер, техникчдэд зориулсан давтан сургалтыг 3 дугаар сарын 31-ний өдрөөс 40 цаг, Шалгалт тохируулгын ажилтны эрх олгох сургалтад 2, АЕГ-ын Баримт бичгийн стандарт, баримт бичиг зохион бүрдүүлэх арга зүй сургалтад 1 ажилтан оролцуулах санал хүргүүлсэн.

Архивын ерөнхий газраас ирүүлсэн 2025 оны Сургалтын төлөвлөгөөтэй танилцаад, оролцох шаардлагатай хичээл сургалтын саналыг ЦУОШГ-ын Цаг уур, орчны шинжилгээний газрын Бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Уянгад цахимаар файл явуулсан.

БНЭАУ-ын Ази, номхон далайн бүсийн Сансрын шинжлэх ухаан, технологийн боловсролын төвөөс зохион байгуулах “Сансрын цаг уур ба дэлхийн уур амьсгал” 14 дэх удаагийн курс сургалтад Нисэхийн цаг уурын бодит ажиглалтын үйлчилгээний инженер О.Төгсжаргал оролцож байна.

БНСУ-ын Сөүл хотод Дэлхийн цаг уурын байгууллагын бүсийн сургалтын төв болох Солонгосын цаг уурын байгууллагаас 05 дугаар сарын 12-23-ны өдрүүдэд “Синоптик инженерүүдийн ур чадварыг дээшлүүлэх” сэдэвт сургалтад Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер Ц.Баярмаа, 06 дугаар сарын 16- 27-ны өдрүүдэд “Цаг агаарын радарын инженерүүдийн ур чадварыг дээшлүүлэх” сэдэвт сургалтад Локаторын ахлах инженер Ч.Наранбаатар оролцсон.

Тус төвөөс 2 жил тутамд зохион байгуулдаг иргэний агаарын тээврийн нислэгт цаг агаарын бодит мэдээгээр үйлчилдэг төв, орон нутгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн нисэхийн цаг уурын бодит ажиглалтын инженер, техникчдэд зориулсан давтан сургалтыг 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн ажлын 4 хоногийн хугацаатай зохион байгуулсан. Сургалтад Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Булган, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүд, Тосонцэнгэл, Ханбумбат нисэх буудлын нисэхийн цаг уурын техникчид, Нислэгийн цаг уурын төвийн нисэхийн цаг уурын бодит ажиглалтын үйлчилгээний инженерүүд оролцсон.

4 дүгээр сарын 28-30-нд СМТАИ С.Ариунболд “Шалгалт тохируулгын ажилтны эрх олгох сургалт”-д давтан оролцсон.

5 дугаар сарын 12-ноос 5 дугаар сарын 13-ны өдрүүдэд Стандарт хэмжил зүйн газар MNS ISO9001:2016 чанарын удирдлагын тогтолцооны 16 цагийн сургалтад Аюулгүй байдал, чанарын хяналтын ахлах мэргэжилтэн Ц.Бадамханд хамрагдаж, гэрчилгээжсэн.

10 дугаар сарын 06-12-ны өдрүүдэд Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер Э.Пүрэвжаргал, Д.Цэрэннамжил нар ЦУОШГ-ын Урьдчилан мэдээлэх хэлтсээс зохион байгуулсан “Синоптик инженерүүдийг мэргэшүүлэх давтан сургалт”-д хамрагдсан.

Төсөл хөтөлбөр, гадаад харилцааны ахлах мэргэжилтэн Х.Агиймаа “Wall Street English” англи хэлний сургалтын төвд англи хэлний дамжаанд суралцаж байна.

11 дүгээр сарын 28-нд Ерөнхий инженер Б.Сүхбаатар, Морин-Уул радар цаг уурын станцын дарга, инженер Х.Энхбаяр, инженер М.Баасанжаргал, Н.Нямбат нар МУИС-аас зохион байгуулсан “Цаг уурын радарын хэрэглээ” сэдэвт ЭШ-ний хуралд оролцсон.

2025 онд дотоодын болон гаднын гаралтай сургалтууд, Олон улсын сургалтад 46 албан хаагч, ЦУОШГ-ын даргын тушаалаар 114 албан хаагч үнэмлэх авсан. Нийт 160 албан хаагч. Санхүүжилттэй холбоотойгоор төлөвлөгөөт сургалтуудаас 7 нь цуцлагдсан.

2025 онд нислэгт цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээгээр үйлчлэх үйлдвэрлэлийн дадлагыг орон нутгийн УЦУОШТ-өөс нийт 11 инженер, техникчид үйлдвэрлэлийн дадлага хийсэн.

Мэргэжлийн эрхийн шалгалт өгч эрх олгосон инженер, техникчид: ЦУОШГ-ын даргын 7 дугаар сарын 02-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар төв болон орон нутгийн синоптик инженер, бодит ажиглалтын мэдээгээр үйлчлэх инженер, техникчдэд мэргэшлийн эрх олгосон.

## **ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын албатай байгуулсан гэрээний 2024 оны биелэлтийг дүгнэж акт үйлдсэн. 1 сарын 6-нд Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албатай байгуулсан гэрээний 2024 оны биелэлтийг дүгнэж акт үйлдэж, ИНҮТ-ийн мэргэжилтэн Ганпүрэвт хүргүүлж баталгаажуулсан.

1 сарын 16-нд Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албатай байгуулсан гэрээний 2024 оны биелэлтийг дүгнэж акт үйлдэж ИНҮТ-ийн мэргэжилтэн Агаарын навигацийн үйлчилгээний газрын НМҮ хариуцсан технологич мэргэжилтэн Б.Янжмаад хүргүүлсэн.

Агаараас эрэн хайх, аврах 111-р анги, Зэвсэгт хүчний 303 дугаар анги, Зэвсэгт хүчний 337 дугаар анги, Томас эйр ХХК, Тэнгэрийн улаач шинэ ХХК, Ажет эвэйшн ХХК-тай байгуулсан гэрээний хүчинтэй хугацаа 1 сарын 15-ны өдөр дуусч байгаатай холбогдуулан гэрээг дүгнэх, сунгах акт үйлдэн холбогдох газруудад [azjargal@thomasair.mn](mailto:azjargal@thomasair.mn), [fltops@tengeriinulaach.mn](mailto:fltops@tengeriinulaach.mn), [tamir@mil.gov.mn](mailto:tamir@mil.gov.mn) хаягуудаар хүргүүлсэн. Агаараас эрэн хайх, аврах 111-р ангитай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчилсэн төслийг [asaru111.nema@gmail.com](mailto:asaru111.nema@gmail.com), хаягаар явуулж гэрээг дүгнэх, сунгах акт үйлдэн 1-2 жилээр гэрээг сунгаж баталгаажуулсан.

АГСА-тай байгуулсан харилцан ажиллагааны журмын 2024 оны хэрэгжилтийг дүгнэж акт үйлдсэн. 4 сарын 9-нд АГСА-аас зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлттэй холбоотой харилцан ажиллагааны журмын шинэчилсэн төслийг хүлээн авч АБЧХХ-ээр хянуулан нэмэлт өөрчлөлт оруулж саналаа хүргүүлж 5 сарын 28-нд баталгаажуулсан.

3 сарын 18-нд “ИНҮТ ТӨХХК-ний зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлттэй холбоотой Буянт-Ухаа ОУНБ-ын харилцан ажиллагааны журмын шинэчилсэн төслийг хүлээн авч нэмэлт өөрчлөлт оруулж, АБЧХХ-ээр хянуулан саналаа хүргүүлж 5 сарын 28-нд баталгаажуулсан.

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албанаас ирүүлсний дагуу НМҮА-тай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ” 2.1.13-д “Тусгагдсан АIP-аар хэвлэн нийтлэгдсэн мэдээлэлд жилд нэг удаа дүн шинжилгээ хийж дүгнэлтийг НМҮА-нд хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу МҮХ-ийн дарга Б.Болормаа, ОНХЕИ Н.Басбиш нар дүн шинжилгээ хийж, дүгнэлтийг АБЧХХ-ээр хянуулан түүхий өгөгдлийг боловсруулан НМҮА-ны WIZARD PORTAL-аар илгээсэн.

ИНЕГ-ын Агаарын навигаци, аэродромын стандартын газрын иргэний нисэхийн хяналтын байцаагчийн 2025 оны БД-425/25 дугаартай дүгнэлтэд тусгагдсан шаардлагын хэрэгжилтийг ханган Эй Си Эйч ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан 5 дугаар сарын 12-нд батлуулсан.

5 сарын 21-нд ИНҮТ ТӨХХК-ний зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлттэй холбоотой НХҮА-наас ирүүлсэн “Харилцан ажиллагааны журам”-д DOC9377-ийн дагуу нэтэлт өөрчлөлт оруулан АБЧХХ-ээр хянуулан АБЧУГ-ын мэрэгжилтэн Ууганбаярт хүргүүлж, 6 сарын 3-нд баталгаажуулсан.

ИНҮТ ТӨХХК-ний зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлттэй холбоотой Аэродром гэрэл суултын алба, Буянт-Ухаа ОУНБ-тай байгуулсан гэрээ батлагдсан. НХНАА-наас ирүүлсэн “Харилцан ажиллагааны журам”-ын төслийг хүлээн авч саналгүй тул АБЧУГ-ын мэрэгжилтэн Гантулгад, НМҮА-наас ирүүлсэн “Харилцан ажиллагааны журам”-ын төслийг хүлээн авч санал боловсруулан АБЧХХ-ээр хянуулан АБЧУГ мэрэгжилтэн Янжмаад 6 сарын 26-нд хүргүүлж, 8 сарын 5-нд баталгаажуулсан.

ЦУОШГ-ын даргын 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн “Гэрээг шинэчлэх ажлын хэсэг байгуулах тухай ” А/154 дугаар тушаалаар нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг ашиглах ерөнхий гэрээг Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-тай шинэчлэн байгуулж, гэрээний биелэлт болон нислэгийн аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр гаргасан баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэх үүрэг бүхий хэсэг томилогдсон. ИНҮТ ТӨХХК-ниас гэрээний шинэчилсэн төслийг хүлээн авч, төвийн дэд ажлын хэсэг нэмэлт өөрчлөлтийн талаар боловсруулсан. ЦУОШГ-аас томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн 7 сарын 29-нд хуралдаж гэрээний төслийг эцэслэн хэлэлцэж, газрын даргад танилцуулсан. Хурлын тэмдэглэл хөтөлж гишүүдээр хянуулсан. ЦУОШГ-аас 7 сарын 29-ны 01/492 дугаар албан тоотоор ИНҮТ ТӨХХК-нд гэрээний саналыг хүргүүлсэн. ИНҮТ ТӨХХК-ний мэрэгжилтнүүдтэй холбогдон гэрээний саналуудад нэмэлт тайлбар өгч ажилласан. ЦУОШГ болон ИНҮТ ТӨХХК хооронд Нислэгт

цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг хэрэглэх тухай ерөнхий гэрээг 8 сарын 20-ны өдрөөс 2 жилийн хугацаатайгаар байгуулсан.

Хилийн цэргийн 0253 дугаар ангийн Хилийн нисэх хэсгийг ХЗДХС-ын 2025 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн А/53 тушаалаар Хилийн цэргийн 0134 дүгээр тусгай нисэх салбар болгон өргөтгөсөнтэй холбоотойгоор Нислэгийн цаг уурын төв болон Хилийн цэргийн 0134 дүгээр тусгай салбарын хоорондын цаг уурын мэдээгээр үйлчлэх, ашиглах талаар хамтын ажиллагааны гэрээг ЦУОШГ-ын хуулийн мэргэжилтэн Болор-Эрдэнээр хянуулан, 2025 оны 11 сарын 17-ний өдрөөс 2 жилийн хугацаатай байгуулан баталгаажуулсан. Аэромонголиа ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дууссан тул хянуулахаар ЦУОШГ-т мэргэжилтэн Болор-Эрдэнэд хүргүүлсэн.

### **СҮЛЖЭЭ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР:**

Төв болон орон нутгийн нислэгийн цаг агаарын мэдээлэл үйлчилгээний ажилд ашиглагдаж буй програм хангамжуудын болон тус төвийн веб хуудасны засвар үйлчилгээ, хөгжүүлэлт, шинэчлэлийн ажлыг хариуцан ажиллаж байна.

MDS-ийн Мэдээний Архив хэсэгт мэдээллүүдийг шүүж харуулахдаа бүртгэлийн хэрэглэгчийн нэрээр харуулдаг байсныг Дотоод хяналтаас шаардсаны дагуу овог нэрээр нь шүүж харуулж мөн шүүж гаргасан мэдээллийг текст файл дээр UTF8 формат (Крилл үсэг)-аар хадгалдаг болгов.

Зүүн өмнөд Азийн бусад улсууд руу ихээр үйлдэгдэх болсон нислэгүүдэд зориулж өндрийн салхи, температурын зурагны программ хангамжийг шинэчлэн Ази тивийн хувьд Төв (30:60, 70:150) болон Өмнөд (0:60, 85:125) гэсэн 2 хувилбараар гаргадаг болгосон.

WAFS-ийн урьдчилсан мэдээний зураглал дээр Монгол улсын агаарын хилийн хаалгануудыг нэмж зураглах ажлыг гүйцэтгэж мэдээлэл үйлчилгээний ажилд оруулсан болно.

НИ-5 хуудсанд SIGMET мэдээллийг гаргахдаа зарим мэдээллийг орхигдуулах алдааг засаж залруулсан. Бичигдэж дамжуулагдсан бүх л мэдээллийг шүүж гаргаж ирэн синоптик инженерүүдэд харуулдаг болгосон. НИ-5 хуудасны орон нутгийн TAF мэдээг татахад TOIM TAF-уудыг орхигдуулж байсныг татаж авдаг болгосон.

Мөн MDS-ийн загвар, дизайныг шинэчлэн сайжруулалт хийсэн. Нууц үг солиход гардаг байсан алдааг засаж, хэвийн ажиллагаанд оруулсан.

9 дүгээр сарын 25-нд “Болор софт” ХХК-тай утсаар холбогдож (77111140) Монгол бичгийн хөрвүүлгийн Кимо программыг Хүний нөөцийн менежер, Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд тус бүр 1 эрх, алдаа шалгагч 10 лицензийг өмнө нь бүртгэлтэй

байсан албан тушаалтнуудад сунгалт хийлгэсэн. Цахимаар ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийг Ахлах нягтлан бодогчид шилжүүлсэн.

### **ДҮГНЭЛТ:**

- 2025 оны үйл ажиллагаа хэвийн явагдсан. Төвийн 2025 оны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 99,3 хувьтай байна.
- Олон улсын 15167, орон нутгийн 8933, онцгой ба тусгай үүргийн 781 нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээ мэдээллээр үйлчилсэн байна. Нислэгт зориулсан цаг агаарын бодит мэдээний ажиглалтыг Чингис хаан ОУНБ-д 17861, Буянт-Ухаа ОУНБ-д 8780 удаа хийсэн. Радарын станцаар үүл, хур тунадасны ажиглалт хийж, 2031400 бүтээгдэхүүнээр үйлчилсэн.
- Буянт-Ухаа ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц өмнөх оны 12 дугаар сарын таарцыг оруулснаар богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 96.15% өмнөх онтой харьцуулахад 0,61%-иар буурсан, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 94.4% буюу 0,89%-иар буурсан. Чингис хаан ОУНБ орчмын богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 94.87% өмнөх онтой харьцуулахад 0,11%-иар буурсан, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 92.7% ба 0,09%-иар буурсан Ханбумбат нисэх буудал орчмын дундаж таарц 92.31% ба 0,15%-иар өссөн байна.
- Буянт-Ухаа ОУНБ-д цаг агаараас шалтгаалсан нислэгийн 11 саатал гарсан. Үүнээс хүлээсэн цуцалсан нислэгийн саатал 11 гарснаас мэдээ таарсан 8, мэдээ таараагүй 3 саатал гарсан. Буянт-Ухаа районы цаг агаараас шалтгаалсан саатал 24. Районы мэдээ таарсан. Замын агаараас шалтгаалсан 4 нислэгийн саатал гарсан. Мэдээ таарсан. Үзэгдэл элементийн хувьд цас, цасан шуургатайгаас хүлээсэн цуцалсан 1, утаа, будантайгаас 2 нислэг, үүлтэйгээс 1, дуу цахилгаантай бороо 2 нислэг, бороотойгоос 5 нислэг тус тус саатсан. Нийт 11 нислэгийн саатлын 80%-иас дээш таарцтай буюу 8 нь мэдээ таарсан, мэдээ таараагүй 3.
- Чингис хаан ОУНБ-д цаг агаараас шалтгаалсан нислэгийн 45 саатал гарсан. Үүнээс буцсан 3, 2-р тойрогт гарсан саатал гарсан 11, хүлээх нислэг үйлдсэн 6, хүлээсэн нислэгийн саатал 25 гарснаас мэдээ таарсан 28, мэдээ таараагүй 15 саатал гарсан. Үзэгдэл элементийн хувьд цас, цасан шуургатайгаас 18, ББХ салхитайгаас 2, ЗЗХ-ын салхитайгаас 1, хөндлөнгийн салхитайгаас 2, шилжлэг салхитайгаас 4, дуу цахилгаантай бороотойгоос 14, манантайгаас 4 нислэг тус тус саатсан. Нийт 45 нислэгийн саатлын 80%-иас дээш таарцтай буюу 28 нь мэдээ таарсан, 17 мэдээ таараагүй.
- Ханбумбат нисэх буудалд цаг агаараас шалтгаалсан 12 нислэгийн саатал гарснаас буцсан 5, хүлээсэн 7 саатал гарсан. Урьдчилсан мэдээ таарсан 4, мэдээ таараагүй 8 саатал.
- “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын бодит ажиглалтын мэдээг өмнөх оны дүнтэй харьцуулахад 0.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

- “Чингис хаан” олон улсын нисэх буудлын бодит ажиглалтын мэдээг өмнөх оны дүнтэй харьцуулахад 0.2 хувиар буусан үзүүлэлттэй байна.
- “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал орчмын уур амьсгалын горимын ажиглалтын мэдээг өмнөх оны дүнтэй харьцуулахад 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- ЦУОШГ болон ИНУТ ТӨХХК хооронд Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг хэрэглэх тухай ерөнхий гэрээ, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Аэродром гэрэл суултын алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба, Буянт-Ухаа ОУНБ, Агаараас эрэн хайх, аврах 111-р анги, Зэвсэгт хүчний 303 дугаар анги, Зэвсэгт хүчний 337 дугаар анги, Томас эйр ХХК, Тэнгэрийн улаач шинэ ХХК, Эй Си Эйч ХХК, Тавантолгой нисэх буудал ХХК, Хилийн цэргийн 0134 дүгээр тусгай салбар зэрэг 13 хэрэглэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, харилцан ажиллагааны журмыг шинэчлэн байгуулсан.
- Монгол улс нь БНХАУ-тай 6 агаарын хаалга Урумчи, Ланжау, Бээжин, Шеньян гэсэн 4 нислэгийн мэдээллийн бүсийн хилээр холбогддог. НЦУТ нь 2025 оны 1 сарын 15-наас эхлэн нислэгт аюултай цаг агаарын үзэгдлийн SIGMET мэдээний агуулга, үйлчлэх хугацаа, газарзүйн байршил ба өндөр, эрчимшил, хугацаа, шилжилтийн талаар хэлэлцүүлгийг UTC-н цагаар өдөр бүр 02 цаг 30 минутаас тогтмол мессеж чат хэлбэрээр хийж байна. БНХАУ-ын цаг уурын байгууллагатай хамтарсан хэлэлцүүлэг хийж SIGMET хамтын ажиллагааны зохицуулалтын платформыг ашигласнаар:
  - Олон төрлийн прогноз зураг мэдээг ашиглах боломж нэмэгдэх
  - Цаг агаарын аюултай үзэгдлийг том масштабаар харах
  - Цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээллийг солилцох,
  - Аянга цахилгаан урьдчилан мэдээлэх индексүүдийн мэдээлэл ашиглах
  - Уулын долгион тооцсон прогноз зураг ашиглах (*Өмнө нь манай оронд ийм үр дүн ашиглах, судлах ажил хийгдэж байгаагүй*)
    - Радар, хиймэл дагуулын бүтээгдэхүүнийг давхцуулж харах (*Хятадын хил залгаа FIR-үүдийн радарын бүрхэц нь манай орны өмнө болон зүүн хэсэгт хамарч байгаа тул үүл тунадасыг илрүүлэх боломжтой болсон. Манай улс төвийн бүсдээ 1 радарын станцтай*)
    - SIGMET мэдээллийн орон зай, цаг хугацаа, үзэгдлийн эрчимшлийг урьдчилан мэдээлэх нарийвчлал сайжрах
    - Урьдчилсан мэдээний чанар, таарц нэмэгдэх
    - Олон Улсын Иргэний Нисэхийн тухай Чикагогийн конвенцын ANNEX 3-ын шаардлагыг хэрэгжүүлэх, SIGMET хамтын ажиллагааны зохицуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой гэж дүгнэж байна.
- 1 сарын 24-ний өдрөөс эхлэн цаг агаарын хэлэлцүүлгийг Буянт-Ухаа болон Чингис хаан ОУНБ-ын ээлжийн урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженерүүд, хэлтсийн дарга, ерөнхий инженер, аюулгүй байдал, чанарын хяналтын хэсгийн

менежер, мэргэжилтнүүдтэй цахимаар (Google meet) хийж байгаа бөгөөд цаг агаарын бодит болон прогноз зураг мэдээ, тоон загварын үр дүн, радар, хиймэл дагуулын мэдээ зэрэгт дүн шинжилгээ хийж тухайн өдрийн цаг агаарын процессыг үнэлэн нэгдсэн дүгнэлт гаргаж байна. Ингэснээр урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженерүүдийн прогнозлох ур чадвар нэмэгдэх, урьдчилан мэдээний чанар таарц өсөх, цаашлаад нислэгийн аюулгүй ажиллагааг хангагдах, агаарын тээвэрлэгчдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх сайн талтай.

- 2025 онд ААЧХХ-ээс Сануулах хуудас-6 (шаардлага-1), Арга хэмжээ авах тухай албан тоот -3, Цаг агаараас урьдчилсан мэдээ таараагүй нислэгийн саатлын төлөвлөгөөт бус үзлэг шалгалтын 26 дүгнэлт, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг шалгалтын 22 дүгнэлт, 16 зөвлөмж гаргаж хүргүүлсэн байна.
- 2025 онд Төв болон орон нутгийн 10 синоптик инженер болон 8 инженер, техникч дадлагажиж, нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчлэх 17 синоптик инженер, бодит ажиглалтын мэдээгээр үйлчлэх 12 инженер, техникчдэд мэргэшлийн эрх олгох шалгалт цахим болон танхимаар авч ЦУОШГ-ын даргын 5 дугаар сарын 13-ны өдрийн А/109 дугаар тушаалаар мэргэшлийн эрх олгосон.
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын хүрээнд Төрийн албан хаагчийн 9%-ийн цомхотголоор 5 албан хаагчийг цомхотгож, орон тооны дээд хязгаарыг 53 орон тоотой батлагдсан.
- Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний тухай хууль шинэчлэхтэй холбоотой хуулийн төсөлд оруулах саналыг хэлэлцэн илгээсэн.
- ИНЕГ-ын Агаарын навигаци, аэродромын стандартын газрын Агаарын навигацийн хяналтын хэлтсийн үзлэг, шалгалтад хамрагдсан.
- Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, 2025-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулах хэлэлцүүлэгт оролцсон.
- 8 албан тушаалтан АТГ-т 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан.
- Барааны тэмдгийн гэрчилгээ 10 жилийн хугацаагаар сунгуулсан.
- Албан тушаалын тодорхойлолтуудад өөрчлөлт оруулсан.
- Нислэгийн цаг уурын үйлчилгээнд Чанарын удирдлагын тогтолцоог “ISO 9001:2015” стандартаар нэвтрүүлснийг гэрчлэх гэрчилгээ авсан.

### **ЦААШДЫН ЗОРИЛТ:**

1. Өндөр гүйцэтгэлийн компьютер ашиглан олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын урьдчилсан мэдээг орон зай, цаг хугацааны өндөр нарийвчлалтай гаргах;
2. Дунд өндрийн болон өндрийн нислэгт зориулан сэгсрэлтийг урьдчилан мэдээлэх арга зүй боловсруулах;
3. Мэдээний таарцыг дээшлүүлж мэдээ таараагүйгээс шалтгаалсан нислэгийн саатлын тоог бууруулах;
4. Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажиллах;
5. ANNEX-III-д орсон 81,82 дугаар нэмэлт өөрчлөлт болон байгууллагын үйлчилгээний онцлог нөхцөл байдалд тохируулан Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журамд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах;
6. Олон улсын Иргэний нисэхийн байгууллагаас 2026 онд Нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөр (USOAP-CMA)-ийн дагуу гүйцэтгэх бүрэн хэмжээний аудит үзлэг шалгалтад амжилттай үнэлгээтэй хамрагдах;
7. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх;
8. Төв, орон нутгийн нислэгийн цаг агаарын мэдээний үйлчилгээний ажилд тогтмол хяналт тавин ажиллах;
9. Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 гэрчилгээ сунгуулах, аудитын шалгалтад бэлтгэж, хамрагдах;
10. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг шалгалт хийж, дүгнэлт гаргах.

ТАЙЛАН БИЧСЭН:

НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.БАТБОЛД